



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.07.05 № 05/9196  
танай \_\_\_\_\_ -ны № 02/992

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ ТАНАА

ТЗУХИТ Х. Мөнхсүрэн


Сүрэн халваруу  
ага хиймт эвсн  
1/8/08

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Жаргалсайханы Баярсайханы хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагад "нягтлан бодох бүртгэл, татвар, эдийн засаг, санхүү, банк, даатгал, бизнесийн удирдлага мэргэжилтэй, Төрийн албаны мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн" байхаар заасныг нэр дэвшигч Ж.Баярсайхан нь хангаагүй байна.

Иймд тус албан тушаалд холбогдох хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР

1422003013674